



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**БАЯНХОНГОР-ОЙЖУУЛАЛТ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН
/АУДИТЫН КОД: БАГ/2017/05-ГА/**



*Ойжуулах талбайн усалгаа, хамгаалалтыг урьдчилан
шийдээгүй мод тарьснаас 58,9 сая төгрөгийн мод ургалзгүй
төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан байна.*

Баянхонгор хот
2017 оны 06 дугаар сар

АГУУЛГА**Тайланг бэлтгэсэн:****Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газар**Газрын дарга, тэргүүлэх
аудитор

Б.Мөнхбат

Аудитын менежер

Д.Цэцэгмаа

Ахлах шинжээч Ё.Сугаррагчаа

Аудитор Б.Должмаа
Аудитор П.Мөнх-Эрдэнэ

Шинжээч Б.Цэрэнчимэд

2017 оны 06 дугаар сар

*Уг тайланг Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын газрын**Цахим хуудаснаас үзнэ үү:*www.audit.bayankhongor.mn*Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 70442584, 70442424
дугаарын утсаар харилцана уу.***Хаяг:** Баянхонгор сум, Номгон
1-р баг, Төр захиргааны ордон
3-р давхар

Товчилсон үгийн жагсаалт	1
Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	2
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	2
Үндсэн мэдээлэл.....	3
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн.....	4
Аудитын хугацаа.....	4
Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл, бусад нөхцөд байдлын талаарх тайлбар.....	4
Бүлэг 1. Ойжуулалттай холбоотой зардлыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар жил бүр баталсан байна.....	5
Бүлэг 2. Ойн зурвас байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг ТБОНХӨБАҮХАТХ-ийн 46.1.1 дэх заалтын дагуу “Баянхонгор сумын хойд талаар 5,6 км ойн зурвас байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулалгүй, ажлын хэсэг байгуулсан байна.....	6-9
Бүлэг 3. Ойжуулах талбайн хамгаалалт, усжуулалтын асуудлыг урьдчилан шийдээгүй атлаа ойжуулалтын ажлыг эхэлсэн, тарьц, суулгацын ургалтанд мэргэжлийн байгууллагаас явцын хяналтыг тухай бүр хийгээгүйгээс 58,9 сая төгрөгийн тарьц суулгац ургалгүй төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан ба 2016 онд төсвөөс дахин 40,0 сая төгрөг олгож нөхөн тарилтыг хийжээ.....	10-28
Аудитын дүгнэлт	28-29
Аудитын зөвлөмж.....	30-32
Холбогдох байгууллагын санал.....	33-36
Саналд өгөх тайлбар.....	36
Тайлан баталгаажуулсан тушаал.....	37-38
Аудитаар тогтоосон албан шаардлага.....	39-42

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮАГ	Үндэсний аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
СДОА	Сум дундын Ойн анги
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ААН	Аж ахуйн нэгж
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1а/399 тоот бичгээр ирүүлсэн захиалга, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

2. Аудитын зорилт

“Баянхонгор ойжуулалт” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн Баянхонгор суманд ойн зурвас бий болгох ажлын хэрэгжилт, үр дүнд аудит хийж, илэрсэн зөрчлийг арилгах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын дүнг аймгийн ИТХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ.Үүнд:

1. Ойжуулалтын төсөл, арга хэмжээг жил бүр төсөвт тусгаж, баталсан эсэх
2. Ойн зурвас байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх
3. Ойн зурвас байгуулах төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд олгосон хөрөнгө үр дүнтэй зарцуулагдсан эсэх

3. Аудитын хамарсан хүрээ

Аудитыг батлагдсан төлөвлөгөөний дагуу Баянхонгор суманд 2013 оноос 2016 онуудад ойн зурвас байгуулах үйл ажиллагаатай холбоотой тендерийн болон санхүүгийн баримт материал, үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад материалыг хамруулан гүйцэтгэв.

4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага Аудитын дээд байгууллагын олон улсын 3000-3100 стандартыг баримтлан, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, судалгаа гаргуулах, дүн, шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актууд болон шаардлагатай бусад баримт бичгийг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хууль, Ойн тухай хууль, БОНХС, Сангийн сайдын хамтарч гаргасан 2009 оны 139/154, 2013 оны А-96/71 тоот тушаалууд болон аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолууд.

Үндсэн мэдээлэл:

2013, 2014 онуудад Баянхонгор суманд хийгдсэн ойжуулалтын ажлыг “БД” ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2015 онд тус компани нэрээ өөрчилж, “Байгалиа дээдлэе” ХХК болжээ.

Баянхонгор сумыг ойжуулах зорилгоор 2013 онд “БД” ХХК-тай төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ойжуулалтад шаардагдах мод, тарьц суулгацыг нийлүүлэх 99,5 сая төгрөгийн гэрээ байгуулж, аймгийн төвийн нийтийн эзэмшлийн 9 талбайд 31000 ширхэг тарьц, суулгац тарьжээ.

Агаарын бохирдлыг бууруулах, элсний нүүдлийг зогсоох, цөлжилтийг бууруулах зорилгоор 2014 онд Баянхонгор сумын хойд талаар 5,6 км ойн зурвас байгуулахаар зураглалыг гарган аймгийн Засаг дарга “БД” ХХК-тай 70,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэрээ байгуулж, 5 төрлийн тарьц, суулгацыг суулгасан байна. Тус ойн зурвасын хамгаалалт, усалгааны асуудлыг шийдээгүй атлаа суулгац тарьсан нь үр дүнгээ өгөөгүй, улиаснаас бусад төрлийн мод ургаагүй тул 2015 онд ойн зурваст усалгааны систем барих ажлыг төлөвлөж, 50,0 сая төгрөгийг 2015 оны аймгийн ОНХС-аас, 169,0 сая төгрөгийг 2016 оны ОНХС-аас гаргахаар төлөвлөжээ. Тус услалтын системийн ажлыг “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ гүйцэтгэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан байна.

“Чандмань-Баянхонгор” ХК өөрийн харилцах дансанд 6 аж ахуйн нэгж, 2 иргэнээс хандивласан 208,3 сая төгрөгийн хандиваар услалтын системийн шахах хоолойг угсрах, хиймэл нуур байгуулах ажлыг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй гүйцэтгэсэн байна.

5,6 км ойн зурваст тарьсан усалгааны асуудлыг шийдсэний дараа 2016 онд 70,0 сая төгрөгийн 17000 ширхэг улиасыг ойн зурваст нөхөн тарилт хийхээр баталж, 2014 онд ой

жуулах ажлыг гүйцэтгэсэн “БД” ХХК-тай 70,0 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2016 онд 40,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон ба тус аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг 2017 оны 01 дүгээр сард цуцалсан байна.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шат бүрт хяналт тавьж, ахлах шинжээч Ё.Сугаррагчаа, аудитор Б.Должмаа, П.Мөнх-Эрдэнэ нар гүйцэтгэв.

Аудитын хугацаа

Гүйцэтгэлийг аудитын төлөвлөгөөг 2017 оны 05 дугаар сарын 15-18-ний хооронд хийж батлуулан, 05 дугаар сарын 19-нд аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн БОАЖГ, СДОА-ийн дарга, холбогдох албан тушаалтнуудад аудитын багийг танилцуулж, аудит эхлэж байгаа талаар мэдээлэл хийж, объект дээрх ажлыг 2017 оны 05 дугаар сарын 22-ний өдөр эхэлж, 06 дугаар сарын 05-ны өдөр дуусгаж, аудитын тайлангийн дүнг мөн сарын 09-ны өдөр аймгийн Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 06 дугаар сарын 15-нд аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, аймгийн БОАЖГ, СДОА, Баянхонгор сумын Засаг даргад хүргүүлэв.

Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл, бусад нөхцөд байдлын талаарх тайлбар

Ойн зурвас байгуулах ажлын гүйцэтгэлийг шалгахдаа бид мэргэжлийн ойн инженерийг ажлын хэсэгт оруулж, дүгнэлт гаргуулахаар төлөвлөсөн боловч аймгийн БОАЖГ, СДОА, ХХААГ-т мэргэжлийн ойн инженер байхгүй байна.

Ойжуулалт хийсэн талбайд тарьсан тарьц, суулгацын амьдралтын хувийг тогтоох хугацаа болоогүй нь аудитын дүгнэлт гаргахад хүндрэлтэй байсныг дурдах нь зүйтэй.

Аудит эхлэхийн өмнө аймгийн ИТХ-аас гүйцэтгэлийн аудитаар шалгуулах ажлыг тодруулахад “5,6 км ойн зурвас, түүнтэй холбоотой ажлын гүйцэтгэлийг шалгуулах”-аар саналтай байсан тул 2013-2016 онуудад аймгийн төвийн ногоон байгууламжид баталж, зарцуулсан хөрөнгийн талаар шалгаагүй, Баянхонгор сумын баруун хойд талаар хийгдсэн таримал ой, түүнтэй холбоотой Хиймэл нуур-услалтын систем, Түйн голын дагуу хийгдсэн таримал ойн гүйцэтгэлийг шалгасан болно.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

Ойжуулалтын төсөл, арга хэмжээг жил бүр төсөвт тусгаж, баталсан эсэх?

Бүлэг 1. Ойжуулалттай холбоотой зардлыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар жил бүр баталсан байна.

Баянхонгор аймагт ойжуулалт хийх, ногоон байгууламж байгуулах ажлын хүрээнд 2013-2016 онд дараах ажлуудыг гүйцэтгэхээр шийдвэрлэж, аймгийн ИТХ-ын хуралдаанаар төсвийг баталжээ. Үүнд:

- 2012 оны 12 дугаар сарын 04-ний аймгийн ИТХ-ын хуралдааны 2/4 тоот тогтоолоор аймгийн 2013 оны төсвийг батлахдаа ОНХС-аас ойжуулалтад зориулж 100,0 сая төгрөг
- 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн аймгийн ИТХ-ын хуралдаанаар 2014 оны төсвийг баталсан 6/2 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар Төв суурин газрын ногоон байгууламжийг цэцэрлэгжүүлэх ажилд ОНХС-аас 100,0 сая төгрөг баталсан боловч 2014.12.19-ний өдрийн 12/2 тоот тогтоолоор 30,0 сая төгрөгөөр бууруулан тодотгож, 70,0 сая төгрөг
- 2014 оны 12 дугаар сарын 04-ний аймгийн ИТХ-ын хуралдааны 11/2 тоот тогтоолоор 2015 оны төсвийг батлахдаа ОНХС-аас Баянхонгор сумын ойн зурваст услалтын систем барих ажилд 50,0 сая төгрөг
- 2015 оны 12 дугаар сарын 05-ны аймгийн ИТХ-ын хуралдааны 14/4 тоот тогтоолоор аймгийн 2016 оны төсвийг баталж, Баянхонгор суманд ойн зурвас байгуулах ажилд 70,0 сая төгрөг баталсан боловч 2016.10.11-ний өдрийн 3/4 тоот тогтоолоор тодотгол хийж уг ажилд 2016 онд олгох санхүүжилтийг 50.0 сая төгрөг болгон бууруулсан байна.
- Мөн 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн аймгийн ИТХ-ын хуралдааны 6/1 тоот тогтоолоор аймгийн нийгэм эдийн засгийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ойжуулалттай холбоотой тусгагдсан 22,0 сая төгрөгийг аймгийн БОАЖГ-ын 2014 оны төсөвт батлагдсан байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхээр шийдвэрлэжээ.

- 2015 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ИТХ-ын хуралдааны 14/3 тоот тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлд Түйн голын сав газарт 3000-аас доошгүй мод тарьж, хайс хамгаалалтыг хийхэд 30,0 сая төгрөг зарцуулахаар тусгасан бөгөөд энэ зардлыг аймгийн БОАЖГ-ын тухайн жилийн Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд батлагдсан 89,5 сая төгрөгөөс зарцуулсан байна.

Ойн зурвас байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх?

Бүлэг 2. Ойн зурвас байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг ТБОНХӨБАҮХАТХ-ийн 46.1.1 дэх заалтын дагуу “Баянхонгор сумын хойд талаар 5,6 км ойн зурвас байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулалгүй, ажлын хэсэг байгуулсан байна.

2.1. 2013-2016 онд ойн зурвас байгуулахад нийт 520,3 сая төгрөгийн өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн ба үүнээс 5 төсөл арга хэмжээний тендерийн урилгыг цаасаар, 1 төсөл арга хэмжээний тендерийн урилгыг цахимаар зарлаж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулжээ.

2013-2016 онуудад дараахь ажилд сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Үүнд:

1. “Баянхонгор ойжуулалт” тарьц суулгац худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо 2013. 04. 17-нд байгуулагдсан. Үнэлгээний хорооны даргаар Ц.Идэрмөнх, нарийн бичгийн даргаар Ч.Оюунчимэг, гишүүдээр О.Байгальмаа, Ч.Эрдэнэцэцэг, Г.Жавхлан нар ажилласан. Тендерт “Эрдэнэмандал эко” ХХК, “БД” ХХК-ууд материалаа ирүүлсэн. Тендер шалгаруулалт мөн оны тавдугаар сарын 03-нд болсон. “Эрдэнэмандал эко” ХХК нь тендерийн баталгаа болон хорио цээрийн дүгнэлт байхгүй, нийлүүлэх тарьц суулгацын хэмжээ, нийт үнийн дүнг ирүүлээгүй тул гэрээ байгуулах эрх олгохоос татгалзжээ.

“Баянхонгор ойжуулалт” тарьц суулгац худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт 99,530,200 төгрөгийн үнийн санал ирүүлсэн “БД” ХХК-ийн

тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж, гэрээ байгуулах эрх олгохыг захиалагчид зөвлөсөн. Аймгийн Засаг дарга 05 дугаар сарын 06-нд гэрээ байгуулах эрх олгох тухай №1а/315 тоот албан бичгийг “БД” ХХК-ийн захиралд хүргүүлсэн байна.

2. “Баянхонгор сумын хойд талаар 5,6 км ойн зурвас байгуулах” тендер зарлах хүсэлт, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг аймгийн Засаг даргын орлогч Д.Ганбаяр 2014.08.06-нд аймгийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн байна. Аймгийн Засаг даргын 2013.06.28-ны өдрийн 367 дугаар захирамжаар “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан босго үнээс даваагүй тохиолдолд харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг ахлагч Ц.Идэрмөнх, нарийн бичгийн дарга Н.Энх-Амгалан, гишүүд Б.Цэрэнлхагва, С.Рэнцэнбямба, Ч.Эрдэнэцэцэг нарын бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Ажлын хэсэг байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйл /Захиалагчийн эрх, үүрэг/-ийн 46.1.1¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Тендер шалгаруулалтыг 2014.10.06-10-нд зарлаж, үнийн санал авахаар мэргэжлийн 3 аж ахуйн нэгжид урилга хүргүүлсэн боловч тогтоосон хугацаанд нэг ч материал ирүүлээгүй. Иймд харьцуулалтын арга амжилтгүй болсон тул хуулийн дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид 2014.10.22-нд хүргүүлжээ.

3. Аймгийн Засаг даргын 2016.02.22-ны өдрийн №а/113 тоот захирамжаар “Түйн голын дагуу ойн зурвас байгуулах” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх тендерийн үнэлгээний хороо /Ц.Идэрмөнх, Н.Энх-Амгалан, Ж.Өсөхбаяр, Х.Бат-Оргил, Д.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй / байгуулагдсан. 2016 оны 02 дугаар сарын 22-29-нд харьцуулалтын аргаар тендер зарлахад тендерийн материал, үнийн санл ирээгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмжийг 2016.03.03-нд аймгийн Засаг даргад хүргүүлжээ.

4. “Баянхонгор сумд ойн зурвас байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2016.02.25-ний өдрийн 121 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүн /Дарга нь Ц.Идэрмөнх, нарийн бичгийн дарга Н.Энх-Амгалан, гишүүд Ж.Өсөхбаяр, Х.Бат-Оргил, Д.Баясгалан /-тэй байгуулсан байна. 2016.03.22-ны өдөр болсон үнэлгээний

¹ “энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах”

хорооны хурлаар “Байгалиа дээдлэе” ХХК-ийн материалыг “хуулийн дагуу ерөнхий шаардлага хангаж байгаа, урьд нь манай аймагт мод нийлүүлж байсан дадлага туршлагатай” хэмээн үзэж, тус компанитай гэрээ байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад 2016.03.23-ний өдрийн 41 тоот албан бичгээр хүргүүлжээ.

5. “Баянхонгор сумын ойн зурваст услалтын систем барих” төслийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2015. 03. 10-ны 119 тоот захирамжаар дарга Ц.Идэрмөнх, нарийн бичгийн дарга С.Рэнцэнбямба, гишүүд Х.Бат-Оргил, Д.Ариунтуяа, Т.Хишигбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр 2015.03.10-нд байгуулсан. Үнэлгээний хороо “Хот тохижилт, үйлчилгээ” ОНӨҮГ-аас боловсруулан гаргаж ирүүлсэн “Ойн зурваст усалгааны систем барих ажлын техникийн нөхцөл, зураг төсөв”-ийн дагуу тендерийн баримт бичиг бэлтгэн, 2015.07. 03-09-ны хооронд харьцуулалтын аргаар зарлаж, урилгыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны “e-procurement.mof.gov.mn” сайтад тавьсан боловч нэг ч үнийн санал ирээгүй байна.

Тендер шалгаруулалт 2015.07.10-нд болж, нэг ч материал, үнийн санал ирээгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмжийг мөн өдөр аймгийн Засаг даргад хүргүүлжээ.

6. “Түйн голын гүүрнээс хүндэтгэлийн хаалга” хүртэлх 11 га талбайд ойн зурвас байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2014 оны 04 дүгээр сарын 03-наас 11-ний хооронд зарлажээ. Тендерийн баримт бичигт заасан хугацаанд нэг аж ахуйн нэгжийн материал ирсэн боловч ерөнхий шаардлага хангаагүй тул гэрээ байгуулах эрх олгохоос татгалзаж, шууд гэрээ байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг 2014.05.08-нд аймгийн Байгаль орчны газрын даргад зөвлөсөн байна.

2.2. ойн зурвас байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй ажил гүйцэтгэх гэрээг хууль журмын дагуу байгуулжээ.

“Баянхонгор ойжуулалт” тарьц суулгац худалдан авах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2013.05.14-ны өдөр тендерт шалгарсан “БД” ХХК-тай гэрээ байгуулсан байна.

“Баянхонгор сумын хойд талаар 5,6 км ойн зурвас байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнийн санал авах тендерт нэг ч материал

ирүүлээгүй тул хуулийн дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид 2014. 10. 22-нд хүргүүлсний дагуу аймгийн Засаг дарга “өмнөх дадлага туршлага, ажлын гүйцэтгэлийг харгалзан” шууд гэрээ байгуулах эрхийг 2014.10.22-ны өдрийн №16/916 тоот албан бичгээр “БД” ХХК-д олгож, гэрээг мөн өдөр байгуулсан байна.

“Түйн голын дагуу ойн зурвас байгуулах” ажилд шууд гэрээ байгуулах зөвлөмжийг 2016.03.03-нд аймгийн Засаг даргад хүргүүлснээр “Дэлгэрэх” нөхөрлөл “Түйн төгөл” ойн зурвас байгуулах 30,0 сая төгрөгийн төсөл бичиж, аймгийн БОАЖГ-тай 2016.05.09-нд “Түйн голын дагуу хашаа хамгаалалт хийж, мод тарих ажлын гэрээ” байгуулсан.

2016.03.22-ны өдөр болсон Баянхонгор сумд ойн зурвас байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны хурлын зөвлөмжийн дагуу аймгийн Засаг дарга 2016.03.25-ны 1а/289 тоот албан бичгээр “Байгалиа дээдлээ” ХХК-тай гэрээ байгуулах эрх олгож, гэрээг мөн сарын 31-нд байгуулжээ.

“Баянхонгор сумын ойн зурваст услалтын систем барих” төслийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгох тендерт нэг ч материал, үнийн санал ирээгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлжээ. Аймгийн Засаг дарга 2015.07.16-ны өдөр тус ажлын ерөнхий гүйцэтгэгч “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын даргатай гэрээ байгуулжээ.

Гэтэл 2015.06.12-ны өдөр Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ, “Чандмань Баянхонгор” ХК-тай “Баянхонгор сумын ойн зурвас, аймгийн төвийн ногоон байгууламж услах услалтын систем барих” төсөл, арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байв.

“Түйн голын гүүрнээс хүндэтгэлийн хаалга” хүртэлх 11 га талбайд ойн зурвас байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт үнийн санал ирээгүй тул шууд гэрээ байгуулах аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг 2014.05.08-нд аймгийн БОАЖГ-ын даргад зөвлөсөн байна. Үүний дагуу 2014.09.15-нд “Түйн голын гүүрнээс хүндэтгэлийн хаалга” хүртэлх 11 га талбайд ойн зурвас байгуулах” ажлыг 22,0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал ирүүлсэн Сум дундын ойн ангитай гэрээ байгуулжээ.

Ойн зурвас байгуулах төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд олгосон хөрөнгө үр дүнтэй зарцуулагдсан эсэх?

Бүлэг 3. Ойжуулах талбайн хамгаалалт, усжуулалтын асуудлыг урьдчилан шийдээгүй атлаа ойжуулалтын ажлыг эхэлсэн, тарьц, суулгацын ургалтанд мэргэжлийн байгууллагаас явцын хяналтыг тухай бүр хийгээгүйгээс 58,9 сая төгрөгийн тарьц суулгац ургалгүй төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдсан ба 2016 онд төсвөөс дахин 40,0 сая төгрөг олгож нөхөн тарилтыг хийжээ.

3.1. БОНХС, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тоот тушаалаар баталсан журмын 4.5 дахь заалтыг зөрчиж, таримал ойн амьдралтын хувийг тогтоогоогүй байхад аймгийн ИТХ-аар батлагдсан хөрөнгийг бүрэн олгосон байна.

Ойжуулалтын ажлыг гүйцэтгэгч ААН-д ойжуулалтын арга хэмжээний нормативт зардлын 50 хүртэл хувийн урьдчилгааг олгож, аймгийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн тарьсан тарьц суулгацын амьдралтын хувиас шалтгаалан үлдэгдэл санхүүжилтийг олгохоор журамласан байхад “БД” буюу “Байгалиа Дээдлэе” ХХК-д ажлын эхэнд санхүүжилтийг бүрэн олгож, БОНХС, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тоот тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 4.5² дахь заалтыг зөрчсөн байна.

² “Ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг гэрээний дагуу санхүүжүүлэхэд дараахь зарчмыг баримтална. Үүнд:

4.5.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу урьдчилгаа төлбөрийн баталгаатай тэнцүү хэмжээтэй урьдчилгаа төлбөрийг төлнө.

4.5.2 Төсөвт зардлын үлдсэн төлбөрийг аймгийн Засаг даргын томилсон ажлын хэсгийн гаргасан актыг үндэслэн тарьсан тарьц, суулгацын амьдралт 75,0 хувиас дээш байвал олгоно.

4.5.3 Тарьсан тарьц, суулгац 50-74,9 хувийн амьдралттай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 90 хувь хүртэл нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгсөнөөр үлдэгдэл санхүүжилтийг тухайн жилд багтаан олгоно.

4.5.4 Тарьсан тарьц, суулгац нь 25-49,9 хувийн амьдралттай ургасан бол гүйцэтгэгчид урьдчилгаагаар олгосон нормативт зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна.

4.5.5 Тарьсан тарьц, суулгац нь 24,9 хүртэл хувийн амьдралттай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойжуулалтын ажлын урьдчилгааг эргүүлэн төлүүлнэ ”

2013-2016 онд аймгийн орон нутгийн төсвөөс ойжуулах ажилд олгосон зардлын төсөв, гүйцэтгэлийг харуулбал:

/сая төгрөгөөр/							
№	Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр	Он	Аймгийн ИТХ-аар баталсан төсөв	Гэрээ байгуулсан мөнгөн дүн	Гүйцэтгэлээр олгосон мөнгөн дүн	Гүйцэтгэсэн байгууллага, ААН	Санхүүжилтийн эх үүсвэр
1	"Баянхонгор ойжуулалт" тарьц суулгац худалдан авах	2,013	100.0	99.5	99.5	"БД" ХХК	Аймгийн ОНХС
2	Баянхонгор сумын хойд талаар 5.6 км ойн зурвас байгуулах	2,014	70.0	70.0	70.0	"БД" ХХК	Аймгийн ОНХС
3	Аймгийн гүүрнээс хүндэтгэлийн хаалга хүртэлх 11 га талбайд ойн зурвас байгуулах	2,014	22.0	22.0	22.0	Сум дундын Ойн анги	Аймгийн БОАЖГ-ын төсвөөс
4	1200 м³ багтаамжтай хиймэл цөөрөм байгуулах, 3000 метр 110 мм-ын 16 ат даралттай шахах шугам угсрах ажил	2,015	0	0	208,3	"Чандмань-Баянхонгор" ХК	ААН-дээс өгсөн хандив, тусламж
5	Ойн зурвасын 5600 метр магистрал 110мм-ын 12 ат даралттай хоолой, 7330 метр 40мм-ын салаалах шугам, 60000 метр 20мм-ын дуслын усалгааны хоолой, 52000 ширхэг дуслын аппарат угсрах ажил	2,015	50.0	219.0	50,0	Хот тохижилт үйлчилгээ ОНӨҮГ	Аймгийн ОНХС-аас 50.0 сая
6	Түйн голын сав дагуу ойн зурвас байгуулах	2,016	30.0	30.0	30.0	Дэлгэрэх нөхөрлөл	Аймгийн БОАЖГ-ын төсвөөс
7	Баянхонгор суманд ойн зурвас байгуулах	2,016	50.0	70.0	40.0	"Байгалиа дээдлэе" ХХК	Аймгийн ОНХС
ДҮН			322,0	510,5	518,9		

3.2 Ойн зурвас байгуулах ажлыг гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн боловч ойжуулсан талбайн хамгаалалт, усжуулалтын асуудлыг урьдчилан шийдээгүй атлаа мод тарьсан, модны ургалтыг дэмжих зорилгоор хөрс сийрүүлэлт болон технологийн дагуу арчилгаа, тордолгоог тухай бүрт хийгээгүйгээс 2014-2015 онд тарьсан суулгацын 64 хувь буюу 58,9 сая төгрөгийн тарьц, суулгац ургаагүй, түүний нөхөн тарилтанд 2016 онд төсвөөс дахин 40,0 сая төгрөг олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Ойн зурваст байгуулах ажилд зарцуулсан хөрөнгийг хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр тус бүрээр танилцуулбал:

1. Аймгийн Засаг дарга Д.Жаргалсайхан, “БД” ХХК-ий захирал Н.Нармандах нар 2013 оны 05 дугаар сарын 14-ны өдөр БХ-2013/11 тоот гэрээ байгуулсаны дагуу 2013 оны 07 дугаар сарын 07-ны өдөр тус компанид 99530,2 мянган төгрөгийг олгожээ.

Тус гэрээгээр “БД” ХХК шинэс 1000, хайлаас 3000, улиас 3000, бургас 4000, шар хуайс 8000, агч 7000, сухай 5000, нийт 99530,2 мянган төгрөгийн үнэ бүхий 7 нэр төрлийн 31000 ширхэг тарьц, суулгацыг 2013 оны 05 дугаар сарын 18-ны дотор нийлүүлэхээр заасан бөгөөд СДОА-ийн даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс 2013.05.14-ны өдөр 01 тоот акт үйлдэж тарьц суулгацыг бүрэн хүлээн авсан байна.

Тарьц, суулгацыг байгууллагуудад хүлээлгэн өгсөн баримт, материал байхгүй ба тарьц, суулгацыг дараахь газруудад олгосон гэсэн тайлбарыг Сум дундын ойн ангийн мэргэжилтэн П.Уртнасан гаргаж өгсөн болно. Үүнд:

№	Тарьц суулгац олгосон байгууллага, ААН	Олгосон тоо хэмжээ /ширхэг/
1	Аймгийн Хөдөлмөрийн хэлтэс /хайлаас/	3,500
2	Баянлиг сум	900
3	Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн 9 нэгж талбай	8,143
4	Сум дундын ангийн мод үржүүлгийн талбай	18,457
Бүгд		31,000

Аймгийн Хөгжимт драмын театр, Гурван бүс цогцолбор, Түүх угсаатны зүйн музей, Төв цэцэрлэг, Жаргалант парк, Мазаалай парк, Ахмадын саад, Цагдаагийн саад, Оготнотой булаг зэрэг аймгийн төвийн нийтийн эзэмшлийн 9 нэгж талбайд дээрх ирсэн суулгацаас 8143 суулгацыг 77 аж ахуйн нэгж, байгууллагад хуваарилж 2013 оны 05 дугаар сарын 11, 17-ны өдрүүдэд тариалалт хийсэн байна.

2. Баянхонгор сумын баруун хойд талаар буюу салхины зонхилох чиглэлд агаарын бохирдлыг бууруулах, элсний нүүдлийг зогсоох, цөлжилтийг бууруулах зорилгоор 2014 онд 5,6 км урт, 50 метр өргөн, 28 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг Н.Нармандах захиралтай “БД” ХХК гүйцэтгэхээр аймгийн Засаг даргын

орлогч Д.Ганбаяртай БХ-2014/ЗДТГ тоот гэрээг 2014 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулжээ.

Аймгийн Засаг даргын 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 594 тоот захирамжаар ЗДТГ-ын даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ойн бүсэд мод тариулах, хяналт тавих комисс байгуулж, мод үржүүлгийн талбайгаас “НИК” ХХК-ийн төв шатахуун түгээх станц хүртэлх 5,6 км бүхий 28 га газарт 25200 ширхэг модыг суулгахаар төлөвлөжээ.


Ойн зурвас байгуулах энэ ажилд 2715 иргэд, ААН, төрийн албан хаагчдыг хамруулан, 1 хүн 9 мод буюу нийт 24435 модыг 10 эгнээгээр тарих хуваарийг гаргаж, захирамжийн 2 дугаар хавсралтаар хариуцсан модыг 90 хувиас дээш ургуулсан 15 байгууллагыг 500,0 мянган төгрөгөөс 10,0 сая хүртэлх төгрөгөөр шагнах уралдааны болзлыг баталсан байна.

“БД” ХХК-ий ажилтан Ч.Мөнхжаргал 25200 ширхэг тарьц суулгацыг Улаанбаатар хотоос авчирч, иргэд, ААН, төрийн албан хаагчдад тарьц суулгацыг хариуцан олгож, мод тарих заавар зөвлөгөөг өгч ажилласан байна.

Нийт 70,0 сая төгрөгийн дүн бүхий тус гэрээгээр 5 нэр төрлийн 2 настай 25200 ширхэг тарьц, суулгацыг 38,8 сая төгрөгөөр нийлүүлж, түүнийг тээвэрлэх зардалд 1,2 сая, томилолтын зардалд 2,0 сая, бэлтгэл болон үндсэн ажил, усалгаа, хамгаалалт, нөхөн тарилт хийх зэрэг ажилд 28,0 сая төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөж, 2014 оны 11 дүгээр сарын 25-ны дотор хүлээлгэж өгөхөөр заасан байна.

Аудитын явцад аймгийн ХХААГ-ын агрономич Б.Мөнхтогтох, БОАЖГ-ын мэргэжилтэн О.Байгальмаа, СДОА-ийн мэргэжилтэн П.Уртнасан, Баянхонгор сумын ЗДТГ-ын байгаль хамгаалагч н.Баньдхүү, “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын ажилтан н.Мөр нарыг оролцуулан 5,6 км ойн зурваст биет тооллого хийхэд 10 эгнээгээр тарьсан мод хоорондын зай харилцан адилгүй, тарьц суулгац суулгахаар ухсан нүхний тоо 21895, ухаагүй нүхний тоо 577, зарим нүхэнд 2-3 модыг тарьсан байв.

Аудитын явцад ойн зурваст явуулсан тооллогын дүнг графикаар харуулбал:



Ургаагүй 3518 ширхэг модноос ургах эсэх нь эргэлзээтэй 204 мод байна. Энэ нь аудит хийсэн хугацаанд модны амьдралтын хувийг тогтоох боломжгүйтэй холбоотой бөгөөд цаашид модны амьдралтын хувийг тогтооход

хамгийн тохиромжтой хугацаа болох 7 дугаар сард ногоон байгууламж, ойн зурвастай холбоотой аудитыг явуулах нь зүйтэй юм.

Аудитын явцад хийсэн тооллогоор 2014 онд “БД” ХХК-аас нийлүүлсэн 25,200 ширхэг модноос 95,4 хувь буюу 36,9 сая төгрөгийн мод ургаагүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж үзэхэд хүргэж байна. Энэ нь тухайн ойжуулах талбайн хамгаалалт, усжуулалтын асуудлыг урьдчилан шийдэж төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

№	Модны төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн	Аудитын тооллогоор ургасан модны		Аудитын тооллогоор ургаагүй модны	
					тоо ширхэг	мөнгөн дүн	тоо ширхэг	мөнгөн дүн
1	Өргөст чацаргана	7500	1200	9,000,000	77	92,400	7423	8,907,600
2	Шар хуайс	2800	1700	4,760,000	133	226,100	2667	4,533,900
3	Жигд	2800	1700	4,760,000	173	294,100	2627	4,465,900
4	Хайлаас	2800	600	1,680,000	238	142,800	2562	1,537,200
5	Улиас	9300	2000	18,600,000	527	1,054,000	8773	17,546,000
ДҮН		25200		38,800,000	1148	1,809,400	24052	36,990,600

Аймгийн Засаг даргын орлогч Д.Ганбаяр, “БД” ХХК-ийн захирал Н.Нармандах нарын хооронд байгуулсан гэрээнд бэлтгэл болон үндсэн ажил, усалгаа, хамгаалалт, нөхөн тарилтад хуваарилсан 28,0 сая төгрөгөөр хэн, хаана, ямар тоо хэмжээний ажил хийж гүйцэтгэх нь тодорхойгүй, тус гэрээний биелэлт, ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан тайлан аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс олдоогүй бөгөөд “БД” ХХК-ий захирал Н.Нармандахаас хийсэн ажлын тайлангийн талаар тодруулгыг утсаар авахад “Манай компани танай аймгаас 23,5 сая төгрөгийн авлагатай, бид модыг гэрээнд заасан тоогоос 3000-4000 ширхэгийг илүү өгч явуулсан, гэтэл мөнгө орж ирсний дараа аймгийн Засаг дарга, СДОА-

ийн дарга нар удаа дараа ярьсан учир бид СДОАнги руу 52,0 сая төгрөгийг буцаасан. Бид нийлүүлсэн тарьц, суулгацын үнийг зах зээлийн үнээс доогуур тооцож өгсөн тул балансад тусгасан авлагаа авмаар байна. Энэ талаар аймгийн Засаг даргын дэргэдэх аудитын алба шалгалт хийж өмнө нь асууж байсан шүү дээ” гэсэн тайлбарыг бидэнд өгсөн.

Аймгийн СДОА-ийндансанд шилжүүлсэн гэх мөнгийг тодруулан шалгахад Төрийн банк дахь цалингийн харилцах дансанд “БД” ХХК-аас 2013 оны 07 дугаар сарын 15-ны өдөр 30755,5 мянга, 2014 оны 10 дугаар сарын 31-ны өдөр 46800,0 мянган төгрөг орж иржээ.

Аймгийн СДОА-ийн данс руу буцаан шилжүүлсэн мөнгөний талаар “БД” ХХК-ий захирлаас эргэж тодруулахад “2013 онд шилжүүлсэн 30,7 сая төгрөг нь 31000 ширхэг тарьц суулгацын арчилгаа, тордолгоонд олгосон мөнгө, харин 2014 оны 46,8 сая төгрөг нь хамгаалалт, усалгаанд олгосон мөнгө” гэсэн тайлбарыг хийсэн болно.

“БД” ХХК-аас Төрийн банк дахь цалингийн харилцах дансанд шилжүүлсэн дээрх мөнгөний талаар, эдгээр гүйлгээний анхан шатны баримт байхгүй байгааг СДОА-ийн даргаар ажиллаж байсан М.Энх-Ирээдүйгээс тодруулахад “холбогдох баримт материалыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтанд өгөөд аваагүй байгаа, энд тэндээс олон газраас намайг асууж шалгасан, шон торны ажлыг Чандмань компани хийсэн, ер нь энэ талаар эргэж санаад баримт материалыг харж байгаад баттай хариу өгье” гэсэн тайлбарыг хийсэн. Аймгийн СХАА-наас СДОА-ийн баримтын талаар тодруулахад “2013 онд шалгалт хийж, баримт материалыг тухайн үед нь буцааж өгсөн, бидэнд аваад буцааж өгөөгүй материал байхгүй” гэсэн хариу ирүүлсэн ба 2013 онд хийгдсэн шалгалтын дүнг файлаар өгсөн болно.

Аудитын явцад “БД” ХХК-аас СДОА руу шилжүүлсэн 77555,5 мянган төгрөгийн зарцуулалтыг нотлох анхан шатны баримт олдохгүй, даргаар ажиллаж байсан М.Энх-Ирээдүйтэй уулзалт хийх боломж, бололцоо хязгаарлагдмал байгаа тул энэ асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах зөвлөмжийг ойн зурвас байгуулах гэрээнд захиалагчийг төлөөлж оролцсон аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлэв.

Сум дундын ойн анги төсвийн байгууллагын ажилчдын цалин олгох харилцах дансаар 2013-2014 онуудад дээрх байдлаар гүйлгээ хийсэн нь Сангийн

сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 24/А-9 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, банкинд нээх, хаах журам-ын 3.12³ дахь заалтыг зөрчсөн байна. Иймд арилжааны банкуудад цаашид энэ талаар анхаарч ажиллах албан бичиг хүргүүлэх зөвлөмжийг аймгийн СТСХэлтэст хүргүүлээ.

3. БД ХХК-ийн гүйцэтгэсэн ойн зурваст нөхөн тарилт хийх 69910,5 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх БХ-2016/ХААА-А/05 тоот гэрээг 2016 онд аймгийн Засаг даргын орлогч Д.Ганбаяр “Байгалиа дээдлэе” ХХК-тай 2016 оны 03 дугаар сарын 31-ны өдөр байгуулж, 2016 онд 50,0 сая, 2017 онд 10,0 сая, 2018 онд 10,0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр гэрээнд заажээ. Тус гэрээний үнийн дүн он тус бүрт олгох үнийн дүнгээс 89,5 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа ба 2016 онд тус компанид 40,0 сая төгрөгийг олгосон байна.

Гэрээнд 1,2-1,5 метрийн өндөртэй, 1 настай 17000 ширхэг улиасыг 2016 оны 04 дүгээр сарын 10-наас 05 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд тарьж, 3 жилийн хугацаанд арчилан хамгаалж ургуулан 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдөр актаар хүлээлгэж өгнө гэж заасны дагуу төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд өмнөх жилүүдийн хуваарьт талбайдаа нөхөн тарилт хийж, “Байгалиа дээдлэе” ХХК-ийн мэргэжилтэн Ч.Мөнхжаргалд хүлээлгэн өгчээ.

Хоёр талын хооронд байгуулсан дээрх гэрээнд улиасыг хэдэн төгрөгөөр нийлүүлсэн, ямар ажил гүйцэтгэсний үндсэн дээр 2017, 2018 онуудад тус бүр 10,0 сая төгрөг олгох нь тодорхой бус бөгөөд үнийн талаар “Байгалиа дээдлэе” ХХК-ий захирал Н.Нармандахаас утсаар ярьж тодруулахад “Нэг ширхэг улиасыг 2500 төгрөгөөр нийлүүлсэн” гэсэн хариуг өгсөн болно.

Аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/618 тоот захирамжаар аймгийн төвийн ар талаар байгуулсан 5,6 км ойн зурвас болон Түйн голын сав дагуу байгуулсан ойн зурваст таригдсан модыг тоолж, амьдралтын хувийг тогтоох ажлын хэсгийг БОАЖГ-ын даргаар ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй комиссыг томилсон байна. Тус комисс 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдөр гаргасан дүгнэлтэндээ “Нөхөн тарилт хийх 17000 ширхэг улиаснаас 15127 ширхэг улиасыг тарьж, 1873 ширхэг улиас нахиа задарч тарилт хийх боломжгүй учир Жаргалан паркын хашаанд суваглан хадгалсан боловч амьдрах

³ “банкинд байршуулж буй харилцах дансыг зөвшөөрөл олгосноос өөр зорилгоор ашиглахыг хориглоно”

чадваргүй болсон учраас тарилт хийгээгүй, тарьсан 15127 ширхэг улиасны 91,4 хувь буюу 13835 ширхэг улиас ургасан” гэж дүгнэсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Дашцэрэн “...гэрээний үүргээ биелүүлж тарих ёстой 17000 ш модоо тариагүй, ойн зурвасын арчлалт, хамгаалалтыг бүрэн хариуцаж ажиллахгүй байгаа тул гэрээ цуцлах мэдэгдлийг “Байгалиа дээдлэе” ХХК-д 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 2/1054 тоот албан бичгийг хүргүүлснийг тус компани хүлээн зөвшөөрч хариу албан бичгийг 2017 оны 01



5,6 км ойн зурваст мод тарьсан талбайн хэсгээс.

дүгээр сарын 11-нд ирүүлж, дээрх гэрээ цуцлагдсан байна. “Байгалиа дээдлэе” ХХК-тай байгуулсан гэрээний 11-т “захиалагч услалтыг хариуцсан 2 ажилчин томилж, цалин хөлсийг олгоно”, 12-т “Захиалагч гүйцэтгэгч талд модыг арчилж, хамгаалах 2

ажилтанг томилж өгнө. Цалин хөлсийг гүйцэтгэгч тал хариуцна” гэж заасан боловч талууд эдгээр заалтыг биелүүлж ажиллаагүй байна.

Иргэн Д.Мягмарбүүвэй, Ц.Хүрэлбаатар нар “Байгалиа дээдлэе” ХХК-тай 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 3 жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээг байгуулсан боловч цалинг сар бүр олгоогүй байна. Иймд тухайн ажилтнууд аймгийн ЗДТГ-т хандаж, өргөдөл гаргасан учир “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-аас иргэн Д.Мягмарбүүвэйд 2016 оны 06 дугаар сарын 10-наас 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацааны ажлын хөлсөнд 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 2067,0 мянган төгрөгийг, иргэн Ц.Хүрэлбаатарт 2016 оны 06 дугаар сарын 10-наас 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацааны ажлын хөлсөнд 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 1486,0 мянган төгрөгийг тус тус олгожээ.

4. “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгийн Түйн голын гүүрнээс хүндэтгэлийн хаалга хүртэлх 11 га талбайд ойн зурвас байгуулах 22,0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэх БХ-2014/А-17 тоот гэрээг аймгийн БОАЖГ-ын

дарга Х.Бат-Оргил, СДОА-ийн дарга М.Энх-Ирээдүй нар 2014 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байгуулжээ.

Гэрээний 3-т зааснаар ажил эхлэхийн өмнө нийт зардлын 50 хувийг гэрээ байгуулагдснаас хойш ажлын 10 хоногт багтаан олгох, үлдэгдэл зардлыг намрын ойжуулалтын ажлын комисс актаар хүлээн авсны дараа амьдралтын хувь 75 хувиас дээш байгаа тохиолдолд олгоно” гэж заасны дагуу санхүүжилтийг бүрэн олгожээ.

Тус ойн зурвасыг хүлээн авсан акт байхгүй байгаа ба 2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бичсэн аймгийн СДОА-ийн ажлын тайлантай танилцахад “аймгийн гүүрнээс хүндэтгэлийн хаалга өнгөртөл 5 км газарт 1000 шонгийн нүх ухах ажлыг иргэн А.Лхагвасүрэнтэй гэрээ байгуулан 339-р ангийн цэргүүд хийж гүйцэтгэсэн, аймгийн төвөөс 1000 ширхэг шон худалдан авч, гэрээт ажилчдаар гүйцэтгүүлсэн, нэг бүр нь 75,0 мянган төгрөгийн үнэ бүхий 37 ширхэг төмөр торыг Улаанбаатар хотоос худалдан авч гэрээт ажилчид болон өөрийн ажилчдаар хийлгэсэн. Ойн зурвас байгуулах газрын хөрс нь үржил шим муутай, хайрган чулуулаг хөрстэй учир 6 удаагийн таталтаар 144м3 хар шороо, 3 удаагийн таталтаар 72м3 бууц татаж, хөрс боловсруулалт хийжээ. Улаанбаатар хотоос бага оврын трактор авчирч 80*70 диаметртэй 3000 ширхэг модны нүх ухуулж, “БД” ХХК-аас 3-4 настай 3100 ширхэг суулгацыг захиалж, эхний ээлжинд улиас, бургас 1700 ширхэгийг тарьсан, тариалалтын ажил аажуу эхэлсэн нь цаг агаар хүйтэрч газар хөлдсөн учир хийх ёстой ажлын 75 хувийг чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн учир хавар тариалалт хийх хүртэл ажлаа түр зогсоогоод байна” гэжээ. Гэвч хавар үлдэгдэл суулгацыг тариалалт хийсэн тухай баримт, тайлан байхгүй, байна.



Аудитын явцад тус газарт тарьсан мод ургаагүй байдал

Энэ талаар СДОА-ийн мэргэжилтэн П.Уртнасангаас тодруулахад “намар 1700, хавар 1800, нийт 3500 ширхэг модыг тарьсан, өвөл Түйн голоос мөс хагалж мод тус бүрт цэнэг усалгаа хийсний үр дүнд ирэх зун нь тарьсан моднууд сайн ургаж байсан боловч дахин арчилгаа хийх төсөв мөнгө байхгүйн улмаас

арчилгаа, усалгааны ажил орхигдсон. Усалгаа, хамгаалалтын асуудлыг шийдээгүй, тухайн газар хөрс муу, хайрган хөрстэй газар тарьсаны улмаас уг таригдсан моднууд амьдрах чадвараа алдсан” гэсэн тайлбарыг бидэнд ирүүлсэн болно.

Аймгийн БОАЖГ нь гэрээгээр хүлээсэн ойжуулалтын ажлын явцад байнгын хяналт тавих, холбогдох мэргэжилтэн болон МХГ-ын улсын байцаагчийг оролцуулан хяналтын тооллого явуулан үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр ажлыг хүлээн авах, намрын тооллогоор амьдралтын хувь 75 хувиас доош байгаа тохиолдолд нөхөн тарилтыг гүйцэтгэгчээр хийлгүүлэх үүргээ биелүүлээгүй, аймгийн СДОА нь холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийг оролцуулсан комисст хүлээлгэн өгөх, ойжуулсан талбайг 3 жил арчилж ургуулж, шаардлагатай үед нөхөн тарилтыг хийх, манаачийг байнга ажиллуулж цалинжуулах үүргээ биелүүлээгүй зэргээс шалтгаалж тарьсан мод ургаагүйгээс төсвөөс зарцуулсан 22,0 сая төгрөгийн үр ашиг гараагүй байна. Тухайн зурваст хийгдсэн шон, төмөр тор аудитын явцад байхгүй байсан тул шон, төмөр торны одоогийн ашиглалтын байдлыг СДОА-ийн мэргэжилтэн П.Уртнасангаас тодруулахад “Хамгаалалт байхгүйгээс шон, тор хулгайд алдагдсан, үерт урсаж алга болсон ба аймгийн БОАЖГ-ын дарга Х.Бат-Оргил “Дэлгэрэх” нөхөрлөлд шилжүүлэх эрхийг олгосны дагуу тус нөхөрлөл хайс, шонг авч ашиглаад 180 ширхэг шонг хашаандаа хураасан байсныг манай анги эргүүлэн авч өөрийн мод үржүүлгийн 3,5 га талбайн хайс, хамгаалалтыг засч сэлбэхэд ашигласан” гэсэн тайлбарыг өгсөн.

“Дэлгэрэх” нөхөрлөлийн ахлагч Б.Должинсүрэнгээс мөн энэ талаар тодруулга авахад “Ашиглалтгүй байгаа шон, төмөр торыг “Дэлгэрэх” нөхөрлөлийг авч ашиглах аман шийдвэрийг БОАЖГ-ын дарга Х.Бат-Оргил өгсний дагуу тус нөхөрлөл өөрсдийн ажилчдын хүчээр 400 орчим шон, 1000 метр торыг авч өөрийн хашаандаа буулгажээ. Үүнээс Түйн голын гүүрнээс хүндэтгэлийн хаалга хүртэл мод тарих зорилгоор хийсэн 500 метрийн урттай 20 метрийн өргөнтэй 8 хайс хийхэд 200 орчим шон, 1000 метр торыг ашигласан ба үлдэх 200 орчим шонг СДОА-ийн дарга М.Энх-Ирээдүй ирж ачиж явсан” гэсэн тайлбарыг хийлээ.

2014-2015 онд ойн зурвас байгуулах ажилд 92,0 сая төгрөг зарцуулж, 28700 ширхэг тарьц суулгац тарьсан боловч, нийт зардлын 64 хувь буюу 58,9 сая төгрөгийн тарьц суулгац ургаагүй байгаа төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан гэж үзэхэд хүргэж байна.

Он	Байршил	/сая төгрөг/			
		Тарьц суулгацын тоо хэмжээ /ширхэг/	Зарцуулсан мөнгөн дүн	Ургаагүй тарьц суулгацын мөнгөн дүн	Нийт зардалд эзлэх хувь
2014	Мод үржүүлгийн талбайгаас "НИК" ХХК-ийн төв шатахуун түгээх станц хүртэлх 5.6 км ойн зурвас бүхий 28 га талбай	25200	70.0	36.9	52.7
2015	Түйн голын гүүрнээс хүндэтгэлийн хаалга хүртэлх 11 га талбай	3500	22.0	22.0	100.0
ДҮН		28700	92	58.9	64.0

Дээрх онуудад тарьсан суулгац усалгаа, хамгаалалт муугаас шалтгаалж ургаагүйн улмаас 2016 онд төсвөөс дахин 40,0 сая төгрөг гаргаж нөхөн тарилт хийсэн байна.

5. Түйн голын дагуу хашаа хамгаалалт хийж, мод тарих 2016/01 тоот ажлын гэрээг аймгийн БОАЖГ-ын дарга Х.Бат-Оргил, Баянхонгор сумын харьяат “Дэлгэрэх” нөхөрлөлтэй 2016 оны 05 дугаар 09-ний өдөр байгуулжээ. Тус гэрээгээр Түйн голын дагуу 10 км хамгаалалтын хайс татах, зурвас байгуулах 3000 ширхэг мод тарих ажилд 30,0 сая төгрөгийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхээр заажээ. Тус ажлыг 2016 оны 05 дугаар сарын 18-аас 07 дугаар сарын 08-ны хооронд гүйцэтгэж, Оготнотой булгаас Эрдэнэцогтын гарам хүртэл 3,8 км урттай, 10 метрийн өргөнтэй талбайд

447 ширхэг шон суулгаж, 3800 метрийн урттай тор татаж хамгаалалтыг хийж, энэхүү талбайд 3600 ширхэг бургас тарьсан.



Түйн голын гүүрнээс хүндэтгэлийн хаалга хүртэл хайс, хамгаалалт хийсэн байдал

Түйн голын гүүрнээс хүндэтгэлийн хаалга хүртэл мод тарих зорилгоор 4,3 км-ийн урттай, 20 метрийн өргөнтэй талбайг хашаажуулж, 1752 ширхэг шон суулгаж, 8920 метрийн урттай тор татаж, 500 метрийн урттай 20 метрийн өргөнтэй 8 хайс хийжээ.

“Байгалиа дээдлэе”

ХХК-аас 2016 оны 05 дугаар сарын 21-ний өдөр аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн О.Байгальмаад хүлээлгэж өгсөн нэг бүр нь 2500 төгрөгийн үнэ бүхий 3000 ширхэг хүрэн бургасыг аймгийн Засаг даргын аман шийдвэрээр Дэлгэрэх нөхөрлөлийн хашаажуулсан талбайд аймгийн БОАЖГ, Бөөнцагаан-Байдраг голын сав газрын захиргаа, Орог нуур Түйн голын сав газрын захиргааны ажилчид нийлж 1340 ширхэг, Залуучуудын холбооны залуучууд 100 ширхэг суулгацыг тарьж, үлдсэн суулгацыг нөхөрлөлийн гишүүд тарьсан байна.

БОАЖГ-ын даргын А/16 тоот тушаалаар байгуулагдсан Түйн голын сав дагуу таригдсан мод сөөгийг тоолох, ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсэг “Дэлгэрэх” нөхөрлөлийн хийж гүйцэтгэсэн хашаа, хамгаалалтыг бүрэн хийсэн гэж үзсэн бөгөөд тус нөхөрлөлийн хашаажуулсан талбайд “Байгалиа дээдлэе” ХХК-аас хүлээн авсан 3000 ширхэг бургасны амьдралтын хувийг 70,4 хувиар тогтоосон байна.

“Дэлгэрэх” нөхөрлөл хашаажуулсан талбайд 2016 оны хавар “БД” ХХК-ийн 3000 ширхэг хүрэн бургасыг тарьсан учир гэрээнд тарихаар тусгагдсан 5,0 сая төгрөгийн үнэ бүхий 3000 ширхэг цагаан бургасыг нөхөрлөлийн гишүүд намар нь тарьсан байна.



Түйн голын дагуу 3 эгнээгээр тарьсан модны байдал

Гэвч “Дэлгэрэх” нөхөрлөлийн тарьсан цагаан бургасны ургалтын хувийг аймгийн БОАЖГ-аас хяналт тавьж, амьдралтын хувийг тогтоогоогүй тул захиалагч аймгийн БОАЖГ-ын хүлээх үүргийн Б-д заасан “гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь аймаг, сумын

холбогдох мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийг оролцуулан үнэлэлт дүгнэлт өгч хүлээн авна”, Д-д заасан “намрын тооллогоор хүлээн авахад амьдралтын хувь 75 хувиас доош байгаа тохиолдолд нөхөн тарилтыг гүйцэтгэгчээр хийлгүүлэх” зэрэг заалтыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах зөвлөмжийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэв.

“Дэлгэрэх” нөхөрлөлийн гүйцэтгэсэн ойжуулсан талбайн шонг хулгайлах, зориудаар торыг эвдэж малаа талбайд оруулдаг, хайсны шонг мал шөргөөж унагаадаг зэрэг бэрхшээлийг нөхөрлөлийн гишүүд ярьж байсан ба орон нутгийн удирдлагаас олон нийтэд сурталчлах, талбайг хаягжуулах, мал бүхий иргэдийг аймгийн төвд нутаглуулахгүй байх шаардлагатай байна.

6. Баянхонгор сумын баруун хойд хэсгээр байгуулсан 5,6 км ойн зурвас, аймгийн төвийн ногоон байгууламж услах услалтын систем барих техникийн тодорхойлолтыг “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ гаргаж, 146,8 сая төгрөгөөр тендерийг зарласан боловч уг тендерт нэг ч ААН материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмжийг тендерийн үнэлгээний хорооноос гаргасан байна. Гэтэл аймгийн Засаг дарга “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-тай 2015 оны 07 дугаар сарын 16-ны өдөр

- 5,6 км ойн зурвасын усалгааны ажил
- Хөгжимт драмын театрын урд талбайн усалгааны ажил
- Ахмадын саадны усалгааны ажил
- Төв замын тусгаарлах зурвасны ногоон байгууламжийн усалгааны

ажлуудыг хийж гүйцэтгэх 219,0 сая төгрөгийн гэрээ байгуулжээ.



5,6 км ойн зурвасын түгээх шугамын усалтын систем

Аймгийн ОНӨГ-аас авсан аймгийн Засаг дарга, “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын хооронд байгуулсан усалтын системийн түгээх шугам хоолой угсрах БХ-2015/ХААА-А/03 тоот гэрээний 3-т “Захиалагч дээрх гэрээний нийт санхүүжилтээс 50,000,000

төгрөгийг аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх ба үлдэгдэл 169,082,633 төгрөгийн санхүүжилтийг 2016 онд шилжүүлэн санхүүжүүлнэ” гэж заасан байхад “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-аас авсан мөн тоот гэрээний 3-т “Захиалагч дээрх гэрээний нийт санхүүжилтээс 50,000,000 төгрөгийг аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх ба үлдэгдэл 169,082,633 төгрөгийн санхүүжилтийн ажлыг гүйцэтгэгч байгууллага өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн хийж гүйцэтгэхээр тохиролцсон болно” гэж гэрээний заалтыг 2 өөрөөр тусгасан байна. Гэвч тухайн ажлын санхүүжилтэнд “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-аас хөрөнгө гаргаагүй ба уул уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, ААН-ээс өгсөн хандив тусламжаар уг ажлыг хийж гүйцэтгэжээ.

“Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Хөдөлмөрийн хэлтсээс ойн зурваст гэрээгээр ажиллах ажилчдын цалингийн зардалд 2015 оны 09-11 сард 3 удаагийн шилжүүлгээр 15,1 сая төгрөг орсныг 11 ажилтанд олгожээ.

7. “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын дарга С.Батдорж, “Чандмань Баянхонгор” ХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Сайнбилэг нар Баянхонгор хотын ойн зурвасын усжуулалтын систем, шахах шугам усралт, хиймэл цөөрөм байгуулах ажлыг хамтран гүйцэтгэх гэрээг 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан байна. Тус гэрээгээр:

✓ Ойн зурвасын 5600 метр магистрал 110мм-ын 12 ат даралттай хоолой, 7330 метр 40мм-ын салаалах шугам, 60000 метр 20мм-ын дуслын усалгааны

хоолой, 52000 ширхэг дуслын аппарат угсрах ажлыг “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ,

✓ 1200 м3 багтаамжтай хиймэл цөөрөм байгуулах, 3000 метр 110 мм-ын 16 ат даралттай шахах шугам угсрах ажлыг “Чандмань Баянхонгор” ХК хийж гүйцэтгэхээр заасан бөгөөд гэрээнд заагдсан ажлыг 2015 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, захиалагч талд хамтран гүйцэтгэгч талууд тус тусын ажлыг хүлээлгэн өгөх үүрэг хүлээжээ.

“Чандмань Баянхонгор” ХК-ий инженер С.Идэрцэцэг “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын гүйцэтгэх ажлын төсөвт өртгийг 219,0 сая төгрөгөөр, “Чандмань Баянхонгор” ХК-ий гүйцэтгэх ажлын төсөвт өртгийг 198,3 сая төгрөгөөр тооцож төсөв гаргаж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Мөн эдгээр төсвийг холбогдох байгууллагаар хянуулаагүй санхүүжүүлсэн, ажлын гүйцэтгэлд аймгийн ГХБХБГ хяналт тавиагүй нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.3⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

Уул уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, ААН аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасны дагуу орон нутгийн хөгжлийг дэмжиж өгсөн хандив, тусламжийн орлогыг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэлгүй, гүйцэтгэгчийн дансанд шилжүүлж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5⁶, 60.3.6⁷ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Чандмань-Баянхонгор ХК-ийн арилжааны банкны харилцах дансанд Жамп ХХК-аас 68,3 сая, Андын тэмүүлэл ХХК-аас 20,0 сая, Арвайн гэгээ ХХК, Жэй Эм Эс Си ХХК-аас тус бүр 30,0 сая, Цастын салхи ХХК-аас 5,0 сая, МБГ ХХК-аас 25,0 сая, иргэн Цэндсүрэнгээс 10,0 сая, Баярмөнхөөс 20,0 сая, нийт 208,3 сая

⁴ “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”

⁵ “Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр нь тулган шалгаж баталгаажуулна”

⁶ “Орон нутгийн хөгжлийн сан нь ... тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламжийн эх үүсвэрээс бүрдэнэ”

⁷ “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг ... орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно”

төгрөгийн хандив төвлөрсөн бөгөөд ямар шийдвэрээр тус компанийн дансанд хандивыг төвлөрүүлснийг тодруулах боломжгүй байна.



5,6 км ойн зурваст хийгдсэн “Хиймэл нуур”

“Чандмань-Баянхонгор” ХК 198,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хиймэл нуур байгуулах, услалтын системийн шахах хоолой угсрах ажлыг ТУЗ-аар батлуулаагүй гүйцэтгэж ТУЗ-ын хуралдааны 18/3 тогтоолоор баталсан хувьцаат компанийн дүрмийн 8.10.3⁸ дэх заалтыг зөрчсөн байна.

Хандиваар орсон 208,3 сая төгрөгөөс хиймэл нуур, услалтын системийн шахах хоолой угсрах ажлын гүйцэтгэлд 206,1 сая төгрөг зарцуулсан байхад 14,5 сая төгрөгийг авлагаар тусгаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4⁹ дэх заалтыг зөрчсөн тул 2017 оны эхний хагас жилд багтаан авлагыг залруулах албан шаардлагыг “Чандмань-Баянхонгор” ХК-д хүргүүлэв.

Аудитаар тус ажилд зарцуулсан мөнгөний зарцуулалтыг шалгахад гаалийн татварт төлсөн гэх 3,3 сая төгрөг нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

3.3 Аймгийн БОАЖГ, СДОА нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, салбарын сайдын тушаалыг хэрэгжүүлэхгүй байгаагаас ойн зурвас байгуулах ажилд тавих хяналт хангалтгүй байна.

Аймгийн БОАЖГ нь БОНСХ, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тоот тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 3.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх, ойн арга хэмжээний ажлыг гүйцэтгүүлж нарийвчилсан жишиг талбайн тооллого явуулж хүлээн авах, түүнийг мэдээллийн санд оруулах, ойжуулалт, ойн арга хэмжээний

⁸ “Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, ТУЗ-д танилцуулан батлуулах”

⁹ “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”

ажлын гүйцэтгэлийн явцад технологийн хяналт тавьж ажиллах, урьд онуудад ойжуулах ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн ААН, байгууллагатай дахин гэрээ хийхгүй байх зэрэг үүргийг хангалтгүй биелүүлж иржээ.

Аймгийн БОАЖГ, СДОА нь Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2009 оны 139/154 дүгээр тушаалаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын 3.3¹⁰-т заасан ойжуулалт, ойн арга хэмжээний ажлыг гүйцэтгэх ААН, байгууллагатай гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулан ажиллах, гүйцэтгэлийг хөтөлж, ойн сангийн өөрчлөлтийг мэдээллийн санд оруулж, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, ойжуулсан талбай бүрт хувийн хэрэг хөтлөх, ойн зурвасыг журмаар батлагдсан маягтын дагуу хүлээж авах зэрэг үүргээ биелүүлээгүй, журмын 3.7.2¹¹-т заасны дагуу мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаагүй байна.

3.4 Төсвийн хөрөнгөөр бий болсон таримал ойг ойн санд хүлээн авах хугацаа болоогүй бөгөөд ойн зурвасыг усжуулах хиймэл нуур, услалтын системийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн үр дүнд бий болсон таримал ой нь БОНХС, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тоот тушаалаар баталсан “Ойжуулалт, ойн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам”-ын 5.8-т заасан шалгуур үзүүлэлт дэхь хугацааг хангаагүй тул ойн санд бүртгэх болоогүй байна.

Аймгийн ОНХС, ААН, байгууллагын хандиваар хийгдсэн “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ, “Чандмань-Баянхонгор” ХК-ийн хооронд байгуулсан гэрээнд Баянхонгор сумын ойн зурвасын услалтын систем, шахах шугам угсрах, хиймэл цөөрөм байгуулах ажлыг 2015 оны 07 дугаарын 16-ны өдрөөс 10 дугаар сарын

¹⁰ “Ойжуулалт хийж байгаа иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага ойжуулсан талбай бүрт 2 хувь хувийн хэрэг хөтөлж, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба болон ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ойн мэдээллийн нэгдсэн санд тус тус хадгалуулна. Ойжуулсан талбайн хувийн хэрэгт ойжуулсан талбайн зураглал, талбайн тодорхойлолт бичиг, ойжуулсан талбайг хэмжиж тогтоосон тухай акт, хилийн зааг, ойжуулсан талбайд тооллого хийж, тарилтын болон арчилгааны жил бүрийн гүйцэтгэлийг хүлээж авсан тухай акт, нөхөн тарилт хийсэн тухай тайлан, таримал ойг орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчид хүлээлгэн өгсөн тухай акт, ой зохион байгуулалтын зураг, төсөлд нэмэлт тэмдэглэл хийх зэрэг материалыг оруулна.”

¹¹ “Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ... ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний чанар, гүйцэтгэлийн байдалд мэргэжлийн үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулна”

16-ны хооронд гүйцэтгэж, гүйцэтгэгч талууд тус тусын ажлыг хүлээлгэж өгөхөөр заасан байхад “Чандмань-Баянхонгор” ХК ажлыг хүлээлгэж өгөөгүй байна.

Харин аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдөр “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын гүйцэтгэсэн услалтын системийн түгээх шугамын ажлыг 100 хувийн саналаар хүлээн авсан хэдий ч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3¹² дэх заалтыг зөрчсөн тул “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын гүйцэтгэсэн услалтын системийн түгээх шугамын ажил, “Чандмань-Баянхонгор” ХК-ийн гүйцэтгэсэн услалтын системийн шахах шугамын ажил-хиймэл нуурыг холбогдох журмын дагуу хөрөнгийг үнэлж, эзэмшигчийг тогтоож, орон нутгийн өмчид бүртгэн, нягтлан бодох бүртгэлд тусгах албан шаардлагыг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

Аудитаар нийт 14,5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага өгөв.

Цаашид анхаарах асуудал: 5,6 км ойн зурваст тарьсан улиас мод нь үндэс томтой тул хөрсний үржил шим, усыг өөртөө ихээр шингээдэг тул бусад мод, ургамлын ургалтанд сөргөөр нөлөөлдөг, том навчтай тул намар түүнийг цэвэрлэхэд бэрхшээлтэй, модыг тарьснаас хойш 10 жилийн дараагаас үрээ хаяж эхлэх үед хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, харшил хөдөлгөх зэрэг үр дагаварууд гарахаар байна. Түйн голд тарьсан бургасын хувьд бусад мод, ургамлын ургалтыг дэмждэг, бургасаар араг, савар хийх зэргээр эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжтой байна. Иймд баруун хойд талаасаа салхилдаг, хөрсний бүтэц муутай манай аймагт цаашид ойн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гарах үр дагаваруудыг тооцож, модны төрлийг сонгох шаардлагатай байна.

¹² “Орон нутгийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн, орон нутгийн өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах.”

АУДИТЫН ДҮГНЭЛТ

“Баянхонгор ойжуулалт” хөтөлбөрийн хэ рэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

1. Ойжуулалттай холбоотой зардлыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар жил бүр баталсан байна.

2. Төв суурин газрын ногоон байгууламжийг цэцэрлэгжүүлэх, ойн зурвас

байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгжтэй хууль, журмын дагуу гэрээ байгуулсан байна.

3. БОНХС, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тоот тушаалаар баталсан журмын 4.5 дахь заалтыг зөрчиж, таримал ойн амьдралтын хувийг тогтоогоогүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

4. Ойн зурвас байгуулах ажлыг гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн боловч ойжуулсан талбайн хамгаалалт, усжуулалтын асуудлыг урьдчилан шийдээгүй атлаа мод тарьсан, модны ургалтыг дэмжих зорилгоор хөрс сийрүүлэлт болон технологийн дагуу арчилгаа, тордолгоог тухай бүрт хийгээгүйгээс 2014-2015 онд тарьсан суулгацын 64 хувь буюу 58,9 сая төгрөгийн тарьц, суулгац ургаагүй, түүний нөхөн тарилтанд 2016 онд төсвөөс дахин 40,0 сая төгрөг олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

5. Аймгийн БОАЖГ, СДОА нь ойн зурвас байгуулах ажилд хяналт тавих хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, журмаар батлагдсан актын дагуу таримал ойг хүлээж аваагүй, таримал ойн хувийн хэргийг нээж хөтлөөгүй байна.

6. Аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор иргэн, ААН-ээс олгосон хандивыг орон нутгийн орлогод төвлөрүүлэлгүй Төсвийн тухай хуулийн 60.2.5, 60.2.6 дахь заалтуудыг зөрчсөн байна.

7. “Чандмань-Баянхонгор” ХК 198,0 сая төгрөгийн өртөг бүхий хиймэл нуур, услалтын системийн шахах хоолой угсрах ажлыг төсвийг өөрсдөө хийж, гүйцэтгэсэн нь ТУЗ-өөр баталсан компанийн дүрмийн 8.10.3 дахь заалтыг зөрчсөн байна.

[Баянхонгор-Ойжуулалт хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн]

БАГ-/2017/05-ГА

8. Төсвийн хөрөнгөөр бий болсон таримал ойг ойн санд хүлээн авах хугацаа болоогүй бөгөөд Ойн зурвасыг усжуулах хиймэл нуур, услалтын системийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

“Баянхонгор ойжуулалт” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох албан тушаалтнуудад дараахь зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Ц.Отгонбаяр танаа

1. “Чандмань-Баянхонгор” ХК, “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮГ-ын гүйцэтгэсэн хиймэл нуур, услалтын системийн ажлыг үнэлж, эзэмшигчийг тогтоож, хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэн, нягтлан бодох бүртгэлд тусгах.

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа

1. Аймгийн хөгжилд зориулж иргэд, ААН-ээс олгох хандивыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, холбогдох хууль, журмын дагуу баталж, зарцуулах.

2. Ойжуулалт, ойн арга хэмжээний ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулахдаа БОНХС, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тоот тушаалаар батлагдсан журамд заасан аймгийн БОАЖГ, СДОА-ийн хэрэгжүүлэх үүрэг оролцоо, хяналт, хариуцлагыг тодорхой тусгаж өгөх.

3. Сангийн сайд, Байгаль орчны сайдын 2009 оны 139/154 дүгээр тушаалаар батлагдсан “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын дагуу ойжуулалт, ойн аж ахуйн ажлын явцад технологийн хяналт тавих, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, гүйцэтгэлийг шалган хүлээн авах ажлын хэсэг байгуулан ажиллуулах.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгальмаа танаа

1. Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 24/А-9 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, банкинд нээх, хаах журам”-ын 3.12 дахь заалтыг хэрэгжүүлж, төсвийн байгууллагын ажилчдын цалин олгох харилцах дансаар цалингаас бусад гүйлгээ хийхгүй байх талаар албан бичгийг арилжааны банкуудад хүргүүлж ажиллах.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Д.Ихбаяр танаа

1. “БД” ХХК-аас аймгийн СДОАнги руу шилжүүлсэн 77555,5 мянган төгрөгийн зарцуулалтыг нотлох анхан шатны баримт олдохгүй байгаа тул энэ асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах.

2. ААН, байгууллага, нөхөрлөл, иргэдээс гүйцэтгэсэн ойжуулалт, ойн арга хэмжээний ажлын тоо, хэмжээ, чанар, үр дүнг тооцсон ойжуулалтын ажлын

намрын тооллогын ажлын хэсгийн актыг үндэслэж эцсийн санхүүжилтийг олгож байх.

**Аймгийн БОАЖГ-ын дарга Б.Бат-Өлзий,
Сум дундын Ойн ангийн дарга Н.Баярсайхан нарт**

1. Орон нутгийн хөгжлийн сангаас ойжуулах, ойн арга хэмжээний ажлыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, хэрэгжилтэд холбогдох хууль, журамд заасны дагуу хяналт тавьж, БОНХС, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тоот тушаалаар батлагдсан журмын 4.5-т заасны дагуу тарьц, суулгацын амьдралтын хувиар санхүүжилтийг олгох

2. ААН, байгууллага, нөхөрлөл, иргэдээс гүйцэтгэсэн ойжуулалт, ойн арга хэмжээний ажлын тоо, хэмжээ, чанар, үр дүнг тооцсон ойжуулалтын ажлын намрын тооллогыг чанартай гүйцэтгэж, нөхөн тарилтыг тухай бүр хийлгэж, таримал ойг журамд заасны дагуу актаар хүлээн авч, ойжуулсан талбай бүрт хувийн хэргийг хөтөлж, байгууллагын ойн мэдээллийн нэгдсэн санд хадгалах.

3. Урьд онуудад ойжуулалт, ойн арга хэмжээний ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн нөхөрлөл, ААН, байгууллагатай БОНХС, Сангийн сайдын хамтарсан 2013 оны А-96/71 тоот тушаалаар батлагдсан журмын 3.2.7-д заасны дагуу орон нутгийн болон улсын захилгаар дахин ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын гэрээг хийхгүй байх

4. Ойжуулах талбайн усалгаа, хамгаалалтын асуудлыг бүрэн шийдсэний дараа экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад ач холбогдолтой, хөрсний бүтэц болон хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй тарьц, суулгацыг сонгож, тарих

**Баянхонгор сумын ИТХ-ын дарга М.Батбаяр,
сумын Засаг дарга Ж.Мөнхсоёл нарт**

1. Мал бүхий иргэдийг аймгийн төвд нутаглуулахгүй байх талаар шийдвэр гаргаж, ойжуулах арга хэмжээний үр дүнд болсон ногоон байгууламжийг хаягжуулж, Баянхонгор сумын сургуулиудын дэргэд “Байгаль хамгаалах” клубыг ажиллуулахад анхаарч, орон нутгийн удирдлагаас олон нийтэд таримал ойг хамгаалах талаар олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах

[Баянхонгор-Ойжуулалт хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн]

БАГ-/2017/05-ГА

Гүйцэтгэлийн аудитаар тогтоогдсон албан шаардлагыг хугацаанд нь биелүүлж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар 2017 оны 10 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ